



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2020 оны 05 сарын 25 өдөр

Дугаар Б/38

Ховд

Г Б.Даваадоржийг ажилд томилох тухай Г

Төрийн албаны тухай 27 дугаар зүйлийн 27.1.1 дэх заалтыг үндэслэн
ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн даргаар Бямбадоржийн Даваадоржийг 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. Б.Даваадоржийг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 72 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээ”-ний ТЗ-10-3 дахь шатлал 981742 төгрөг /Есөн зуун наян нэгэн мянга долоон зуун дөчин хоёр/-өөр цалинжуулж, Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 10 хувиар үндсэн цалингаас тооцож олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, аж ахуйн албаны дарга бөгөөд ахлах нягтлан бодогч /Б.Нямдэлгэр/-д зөвшөөрсүгэй.

3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Б.Даваадоржид үүрэг болгосугай.

4. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн даргын ажил хүлээлцүүлэх ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
даргын 2020 оны 05 дугаар сарын 25-ны
өдрийн Б/38 дугаар тушаалын хавсралт



АЖИЛ ХҮЛЭЭЛЦҮҮЛЭХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	Б.Ганболд	–Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
Гишүүд:	Ц.Оюунчимэг	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн мэргэжилтэн
	Б.Энхмандал	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч

-оОо-